

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021.01.11

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Ажил үйлчилгээ	Биелэлт
Нэг. Төрийн албаны шинэтгэл, Хүний нөөцийн бодлого, гүйцэтгэлийн удирдлагын чиглэлээр			
1	<p>1.1. Төрийн албаны тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шаардлагыг ханган ажиглах.</p>	<p>1.1.1. Төрийн албаны зөвлөлөөс давшуулсан Төрийн албаны шинэтгэлийн стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулах зорилтын хүрээнд ШШГЕГ-ын "ШШГБ-ын Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн боловсруулж, батлуулах</p>	<p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2020 оныг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах жил" болгон зарлаж, энэхүү зорилтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулах "Ажлын хэсэг"-ийг ШШГЕГ-ын даргын 2020.02.28-ны өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулан ажиглуулж, ШШГЕГ-ын даргын 2020.05.15-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх 2020-2024 оны дунд хугацааны хөтөлбөр"-ийг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиглаж байна.</p> <p>Дээрх хөтөлбөр нь хүний нөөцийн удирдлагын бодлого, чиглэл, шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээлэл сурталчлах, хүний нөөцийг судлах, бүрдүүлэх, шилж сонгох, байршуулах, сурган дадлагажуулах, мэргэшүүлэх зэрэг стратегийн асуудлыг бүрэн тусгаж баталгаажуулсан.</p> <p>-"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх 2020-2024 оны дунд хугацааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн талаар харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжүүдээс тайлан, мэдээг гаргуулан авч, жилийн эцсийн байдлаар нэгтгэж, үр дүнг тооцсон.</p> <p>-ШШГЕГ-ын харьяа байгууллагуудын сул орон тоонд тус байгууллагад ажилд орох хүсэлт гаргасан, ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн харуул хамгаалалтын ажиглан бэлтгэх сургалтад хамрагдсан 503 иргэнийг судлан зохион албан тушаалд томилсон.</p> <p>Алба хаагчдын ажлын сахилга харууллагыг дээшлүүлэх, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар ШШГЕГ-ын даргын "Ажил эрчимжүүлэх тухай" 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр</p>

		<p>албан даалгаварт тусгуулан, харьяа хорих анги, байгууллагуудад хургуулан биелэлтийг хагас, бүтэн жилийн байдлаар нэгтгэн дүгнэсэн.</p> <p>-Мөн шинээр томилогдсон алба хаагчдыг ажилд нь дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл бололцоогоор хангах, байгууллагын болон албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийн онцлогийг таниулан ойлгуулах талаар 2020.06.19-ний өдрийн 02/3128, 2020.10.30-ны өдрийн 02/5149 дүгээр албан бичгээр үүрэг чиглэлийг хургуулан, биелэлтийг хангуулан ажилласан.</p>
	<p>1.1.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд жөндөрийн эрх тэгш байдлыг хангуулах арга хэмжээ авч ажиллах</p>	<p>1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа 51 анги, байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгуулан, биелэлтийг тооцон ажиллаж ирлээ.</p> <p>2. ШШГЕГ-ын даргын 2020.05.28-ны өдрийн А/96 дугаар тушаалаар батлагдсан "ШШГБ-ын Хөдөлмөрийн дотоод журам"-д Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйл, ажлын байран дахь аливаа дарамтаас урьдчилан сэргийлэх, түүнээс ангид орчин бүрдүүлэх, сургалт зохион байгуулах, гомдлыг шийдвэрлэх харилцааг нэмж тодруулан тусгасан.</p> <p>Мөн анги, байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн дээрх журамд "Амаржсаны амралтаа дуусгаад хүүхэд асрах чөлөө авсан эмэгтэй алба хаагчид чөлөөтэй байх хугацаанд нь цолны цалинг олгож болно. Цолны цалинг Ерөнхий газар болон салбар нэгжийн даргын тушаалаар шийдвэрлэнэ" гэж тусгаж өглөө.</p> <p>3. ХЗДХЯ болон Жөндөрийн үндэсний хорооноос хамтран зохион байгуулж буй жөндөрийн цахим сургалтад 74 удирдах албан тушаалтнуудыг хамруулж, Ж1 гэрчилгээ олгосон.</p> <p>4. "Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт "Яг Одоо жөндөрт суурилсан хүчирхийллийг цэглээ" аяны хүрээнд байгууллагын цахим сайтад уриалга, зурагт хуудас зэргийг байршуулан олон нийтэд сурталчилсан.</p> <p>5. Харьяа анги, байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх түвшний алба хаагчдад "Донтолт", "Жөндөрийн тухай ойлголт, жөндөрт суурилсан хүчирхийлэл", "Ажлын байран дахь бэлгийн дарамт", "Төрийн албан дахь жөндөрийн эрх тэгш байдлын баталгаа", "Жөндөр ба хүний эрх бүх нийтийн эрх зүйн боловсрол", "Ажлын байр, бэлгийн дарамтгүй орчин", "Ажлын байрны аливаа төрлийн дарамт", "Хүйс ба Жөндөр", "Бэлгийн дарамт", "Хүйсийн төлөөллийн доод хязгаар", "Жөндөрийн мэдрэмжтэй байгууллагыг төлөвшүүлэх нь", "Жөндөрийн тэгш байдал, хөгжлийг бүтээхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцох боломж",</p>

		<p>“Хүчирхийллийн тухай”, “Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, түүнийг орон нутагт хэрэгжүүлэх нь”, “Байгууллагын хүний нөөцийн бодлогод жендэрийн асуудлыг тусган, үр дүнтэй хэрэгжүүлэх нь”, “Гэр бүлийн харилцаа, ёс зүй, гэр бүлийг төлөвшүүлэх нь”, Хүйсийн төлөөллийн доод хязгаар” зэрэг сэдвүүдээр сургалт цахимгаар зохион байгуулсан.</p> <p>6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019.07.05-ны өдрийн А/127 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийг байгуулан, ШШГЕГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар “ШШГБ-ын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дүрэм”-ийг батлан анги, байгууллагад хүргүүлсний дагуу харьяа 51 анги, байгууллага “Эмэгтэйчүүдийн зөвлөл” байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2020 оны “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг анги, байгууллагуудаас авч нэгтгэн баталж, хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>7. ШШГЕГ-ын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн цахим хуудсыг нээн баяжилтийг тухай бүр хийж байна.</p> <p>8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа анги, байгууллагуудын эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран системийн хэмжээний эмэгтэй алба хаагчдыг хамруулан “Хандивын аян”-ыг зохион байгуулж, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч Ж.Эрдэнэцэцэгийн хүүхдийн эмчилгээний зардалд мөнгөн хандив цуглуулж өгч, 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн залуу алба хаагчид байшин барихад хандив олгох, Говьсүмбэр аймаг дахь ШШГТ-ын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн үйл ажиллагаатай УИХ-ын гишүүн П.Анужинд танилцуулах, 401 дүгээр хаалттай хорих ангитай хамтран Эмэгтэй алба хаагчдыг эмэгтэйчүүдийн хавдрын үзлэгт хамруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.</p>
	<p>1.1.4.“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу нийт албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийх ажлын явц байдалд хяналт тавин, хэрэгжилтийг хангуулах;</p>	<p>“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөн ажиллаж удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр болон алба хаагчийн өргөдөл, шилжсэн, халагдсан, чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан, шилжүүлэн томилсон, сахилгын арга хэмжээ авсан нийт 37228 алба хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр албан тушаалд томилогдсон 360 алба хаагчийн хувийн хэргийг нээн товъёог хөтөлж, харьяа газар, анги, алба нэгжид байршуулсан.</p>

		<p>ШШГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/237 дугаар тушаалаар алба хаагчдын 2020 оны ажлын үнэмлэхний загварыг батлуулж, шинэчилсэн загварын дагуу 4526 алба хаагчийн ажлын үнэмлэхийг хэвлэн олгож, хуучин үнэмлэхийг хураан авч устгал үйлдэн ажилласан.</p> <p>-Анги, алба салбар нэгжийн өөрийн болон захиргааны санаачилгаар чөлөөлөгдсөн 206, тэтгэвэрт гарсан 82, халагдсан 25, нас барсан 3, бусад байгууллагын мэдэлд шилжүүлэх 20, нийт 336 алба хаагчийн материалыг баяжилт хийн Төв архивт шилжүүлэн ажилласан.</p>
	<p>1.1.5.Төрийн албаны шатлан дэвших нөөцөд хамрагдах төрийн албан хаагчдын судалгааг гаргаж, шатлан дэвшүүлэх болзол, шаардлагыг хангасан алба хаагчдыг томилох бодлого, зарчмын хэрэгжилтийг хангуулж ажиллах</p>	<p>ХЗДХС-ын 2018 онд баталсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам"-д заасан болзол, шаардлагын дагуу харьяалах нэгжүүдээс ирүүлсэн санал, алба хаагчдын хүсэлтийг үндэслэн 404 алба хаагчийг албан тушаалд шилжүүлэн томилсон байна.</p> <p>Төрийн алба хаагчдын ажил хөдөлмөрийн үр дүнг үнэлж, сайшаан урамшуулах, зөрчил, дутагдал гаргасан тохиолдолд сахилын шийтгэл ногдуулах асуудлыг зохих хууль, журмын хүрээнд шийдвэрлэн ажиллаж ирлээ.</p> <p>2020 онд алба хаагчдын шагнал, урамшууллын байдлыг нэгтгэхэд: -Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар нэр бүхий 31 албан хаагчийг төрийн дээд одон медалиар шагнасан. Үүнд: "Цэргийн хүндэт медаль"-иар 25 алба хаагч, 5 ахмад ажилтан, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар 1 ахмад ажилтан тус тус шагнагдсан. -Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар нэр бүхий 451 алба хаагчийг шагнасан. Үүнд: "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр 11, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэргүүний ажилтан" тэмдгээр 123, "Хүндэт жуух бичиг"-ээр 317 алба хаагч тус тус шагнагдсан.</p>
	<p>1.1.6.Алба хаагчдын шилжилт хөдөлгөөн, шагнаж урамшуулах, харууцлага тооцох ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж буйд хяналт тавин, холбогдох албан тушаалтанд танилцуулан шийдвэрлүүлэх</p>	

			<p>-“Цэргийн цол олгох журам”-ын дагуу цэргийн цол хоорондын хугацааг баримитлан тэмдэглэлт ойг тохиолдуулан ШГА, хорих ангиас ирүүлсэн санал, тодорхойлолтыг үндэслэн цэргийн ээлжит цолоор эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 722 алба хаагчид цэргийн цол олгосон. Үүнд: “Хурандаа” цолоор 17, “Дэд хурандаа” цолоор 36, “Хошууч” цолоор 105, “Ахмад” цолоор 94, “Ахлах дэслэгч” цолоор 102, “Дэслэгч” цолоор 91, “Ахлах ахлагч” цолоор 93, “Ахлагч” цолоор 86, “Дэд ахлагч” цолоор 98 алба хаагч.</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд шагнал урамшуулал олгох журам”-ын дагуу шагнал хоорондын хугацааг баримитлан тэмдэглэлт ойг тохиолдуулан ШГА, хорих ангиас ирүүлсэн санал, тодорхойлолтыг үндэслэн өнөөдрийн байдлаар эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан алба хаагчдыг дараах байдлаар шагнаж урамшуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн хуяг шагналаар 2 - Хүндэт ажилтан тэмдгээр 11 - Албаны төлөө I зэргийн тэмдгээр 40 - Салбарын тэргүүний ажилтан 73 - Албаны төлөө II зэргийн тэмдгээр 56 - Тэргүүний шийдвэр гүйцэтгэгч 1 - Хүндэт тэмдгээр 133 - Албаны төлөө III зэргийн тэмдгээр 172 - Баярын бичгээр 129, нийт 617 алба хаагчийг тус тус шагнажээ. <p>Эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн 14 алба хаагчийг албан тушаал бууруулах, 25 алба хаагчийг албанаас халах, 90 алба хаагчид бусад төрлийн сахилгын шийтгэлийг ШШГЕГ-ын даргын тушаалаар, 481 алба хаагчид анги, нэгжийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан нь нийт алба хаагчдын 19.3 хувийг эзэлж байна.</p>
2	<p>2.1. Алба хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг хөгжүүлэх</p>	<p>2.1.1.Харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, архив, бичиг хэргийн ажилтнуудын ажлын байран дахь сургалт, мөн хүний нөөцийн мэргэжилтэний мэргэшүүлэх давтан сургах сургалтыг тус тус зохион байгуулах</p>	<p>Хоёр. Төрийн албаны хүний нөөцийн мэдлэг боловсрол, хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт</p> <p>Харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн хүний нөөцийн мэргэжилтэний мэргэшүүлэх давтан сургалтыг ШШГБ-ын “Хүний нөөц, хувцас хангалт”-ын шинэчилсэн програм сэдвээр цахим хэлбэрээр 2020.11.10 /хотын бүсийн хорих анги/, 2020.12.04-ний /орон нутаг дахь хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгж/ өдрүүдэд 2 удаа зохион байгуулж хотын бүсийн 23, орон нутаг дахь хорих анги, газар, салбар нэгжийн 35, нийт 55 алба хаагчийг хамруулсан.</p>

		<p>Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан журам, зааврыг алба хаагчдад мэдээлэн сурталчилж судлуулах, хүний нөөцийн холбогдолтой асуудлыг шийдвэрлүүлэхээр ШШГЕГ-т уламжлахдаа анхаарах зарим асуудал зэргээр тодорхой үүрэг чиглэлийг анги, нэгжийн удирдлага, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт өгч, биелэлтийг хангуулж ажилласан.</p> <p>ШШГЕГ-ын даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/197 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын дунд 2019-2020 онд зохион явуулах албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө"-ний дагуу албаны болон мэргэшүүлэх, давтан сургалтыг зохион байгуулсан болно.</p> <p><i>Алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтын талаар:</i></p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс, салбар нэгжийн дотоод хяналт шалгалт, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх сургалтад 50; - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс, салбар нэгжийн нийгмийн ажиглан, сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх цахим сургалтад 78; - Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа, төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч, шинжээч оролцуулахад анхаарах асуудал болон дуудлага худалдааны явцад хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгох сургалтад 270; - Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хөрөнгийн мэдээлэл, хугацааны санчуулга бүхий алба хаагчдад зориулсан "ШГД мэдэгдэл" нэртэй гар утасны аппликэйшныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, аргачлалын сургалтад 270; - "Удирдах ажилтны манлайлал, ёс зүй" сэдэвт цахим сургалтад анги байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, цагдан хорих байрны дарга нарын нэр бүхий 21; - "Архив, албан хэрэг хөтлөлт"-ийн сургалтад 51; - Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэхтэй холбоотой сургалтад 55, нийт 795 алба хаагч тус тус хамрагдсан.
<p>2.1.2.Байгууллагын алба хаагчдад 2019-2020 онд зохион байгуулах албаны болон мэргэшүүлэх, давтан сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллана</p>		

		<p>Алба хаагчдын богино хугацааны сургалтын талаар:</p> <ul style="list-style-type: none"> - Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллах байгаа нэр бүхий 57 алба хаагчид амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардаж авсан. - Мөн Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, төрийн алба хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3 алба хаагч суралцаж байна. - 409 дүгээр хаалттай хорих анги нь бүлгээр болон шинээр томилогдож ирсэн алба хаагчдыг сурган дэдлагажуулах модуль сургалтын танхим, номын сан, интернэт уншлагын танхим байгуулсан. <p>Харьяа анги, байгууллагуудад 2019-2020 онд зохион байгуулсан сургалтыг нэгтгэн дүгнэхэд:</p> <ul style="list-style-type: none"> - "Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалт" 100%; - "Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалт" 97%; - "Шинээр батлагдсан хууль, журам заавар, нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалт" 95%; - "Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшлүүлэх сургалт" 95%-ийн биелэлттэй тус тус зохион байгуулагдаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан. <p>Төрөл, мэргэжлийн чиглэлээр алба хаагчийг мэргэшүүлэх сургалтыг төвлөрсөн, бүсчилсэн, зайны буюу цахим, ажлын байран дээрх сургалтын хэлбэрээр зохион байгуулсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020.03.05-ны өдрийн А/42 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх "Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр" дунд хугацааны сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан, харьяа анги, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд анги байгууллагуудаас англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй нийт 16 алба хаагчийг шалгаруулан "English one" сургалтын төвд байгууллагын зардлаар 35 хоног суралцуулсан.</p> <p>"Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр" дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хүрээнд нийт анги байгууллага, салбар нэгжүүд тодорхой ажлуудыг үе шаттай хэрэгжүүлснээр эхний шатны арга хэмжээ амжилттай зохион байгуулагдаж, нийт алба хаагчид англи хэлний анхан шатны мэдлэгтэй болох зорилтын биелэлт хангагдлаа.</p>
--	--	--

	<p>2.1.3.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх асуудлаар байгууллагын хэмжээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагаар хангах;</p>	<p>-Салбар зөвлөлийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр ШШГЕГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиглаж байна.</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47-р тушаалаар батлагдсан Байгууллагын болон төрийн жинхэнэ алба хаагчийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх аргачлалыг боловсруулсан төслийн удирдагч Ц.Амарбаясгалангаар хотын бүсийн анги, байгууллагын төлөвлөглт, тайлан мэдээний биелэлт хариуцсан алба хаагчдад сургалт зохион байгуулсан.</p>
	<p>2.1.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиглах;</p>	<p>Алба хаагчдын ая тухтай, хэвийн ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, амьдралын түвшин, ахуй нөхцөлийг дээшлүүлэх, амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын 2016.11.14-ний өдрийн А/220 дугаар тушаалаар "ШШГБ-ын алба хаагчдын ажиглах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлан 2016-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, чиглэл гарган ажиглаж байна.</p> <p>ШШГЕГ-ын системийн хэмжээнд 2020 онд 57 нэгжид нийт 4028.9 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, 302,9 сая төгрөгийн НДШ-н зардалыг батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд алба хаагчдын албан хэрэгцээнд зориулж нэгдсэн хангалтаар техник, тоног төхөөрөмжид 35,322,939, тавилга эд хогшилд 48,076,450, бичиг хэргийн зардалд 20,627,611 төгрөг тус тус зарцууллаа.</p> <p>2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 3280 цэргийн алба хаагчдад 29 нэр төрлийн 1,216.8 сая төгрөгийн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг олгосон.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулж, алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Миг даатгал" ХХК, "Монгол даатгал" ХХК-уудад 117.4 сая төгрөгийн гэрээ байгуулан даатгуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг баримтлан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх алба хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн 1503.3 сая төгрөг олгосон. Ажлын шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 21 алба хаагчид 27.4 сая төгрөг, 11 алба хаагчийн цолны мөнгийг тус тус олгосон.</p>

		<p>Тайлант хугацаанд тэтгэвэрт гарсан 58 албан хаагчид 1,831.7 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, 78 албан хаагчид 679.4 сая төгрөгийн, албан үүргээ гүйцэтгэж байгаад нас барсан 3 алба хаагчийн ар гэрт 117,5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, ШШГЕГ-ын албан хаагчдын хүүхдэд 5,330,277 төгрөгийн бэлэг тус тус олгосон.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн алба хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам"-ын дагуу 3 алба хаагчид эрдмийн зэргийн нэмэгдлийг олгохоос гадна ШШГЕГ-ын даргын тушаалаар 5 алба хаагчид албан тушаалын цалингийн 30-40 хувийн нэмэгдэл олгож байна.</p> <p>Алба хаагчдыг зах зээлийн үнээс хямд үнээр орон сууцаар хангах зорилт тавин ажилласнаар нийслэлд 254, орон нутагт 72 нийт 326 айлын орон сууцныг барьж ашиглалтад оруулан алба хаагчдад хүлээлгэн өгсөн.</p> <p>Алба хаагчдын амьдралын түвшин, ахуй нөхцөлийг дээшлүүлэх зорилтын хүрээнд 51 алба хаагчдад зуслангийн газар олгуулах, 20 айлын газрын асуудлыг шийдвэрлэх, 3 алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах, хөнгөлттэй үнээр хүнсний зүйлс болон мал олгох, 27.647.900 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлэх, 10 алба хаагчийг орон сууд, хашаа байшингаа засварлахад нь зориулж хүн хүч, эд материалын тусалцаа, 20 алба хаагчийн амьдралд нь дэм өгөх, эдийн засгийн баталгааг хангах зорилгоор 100.000.000 төгрөгийн мөнгөн тусламж тус тус олгожээ.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа анги, байгууллагууд Засгийн газрын болон Улсын онцгой комиссын удаа дараагийн тогтоол, шийдвэрийн дагуу улсын хэмжээнд зарласан өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал зарласан хугацаанд Короновируст халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй болон шаардлагатай ажилтан, алба хаагчийг гэрээсээ ажиглах нөхцөл боломжоор хангаж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр богиносгосон цагаар ажиллуулах, цалинтай чөлөө олгох, ээлжинд амралтыг олгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүрт нь хэрэгжүүлж ирлээ.</p> <p>"Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал" буюу гадаадад суралцагчдын зардлаас гадаадын их, дээд сургуулийн бакалавр, адъюнктур, докторантурт суралцаж буй 21 алба хаагчдад цолны мөнгө, тэтгэлэг, замын зардалд 137,6 сая төгрөг олгосон зэргээр алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлсэн болно.</p>
--	--	---

<p>3</p>	<p>2.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар төрийн албан хаагчдын соён гэгээрүүлэх, зөрчлөөс сэргийлэх, хяналт тавих, гаргасан зөрчлийг таслан зогсоох, цаг тухайд нь шийдвэрлэх, холбогдох албан хаагчдад хармуцлага хүлээлгэх,</p>	<p>2.2.1. "Төрийн албаны сахилга, дэг журмыг чангатгах тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоол, албан даалгаврын хэрэгжилтийн тайлан, танилцуулгыг танилцан судалж, холбогдох үүрэг, чиглэл өгч биелэлтэд хяналт тавих</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын "Төрийн албаны сахилга, хармуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоол, Засгийн газрын "Сахилга, хармуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2017 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг хангуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил бүрийн эхэнд ШШГЕГ-ын дарга батлан, харьяа хорих анги, байгууллагуудад хүргүүлсний дагуу тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэн ажиглаж байна.</p> <p>Дээрх тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх тайлан, мэдээг харьяа анги, байгууллагуудаас улирал тутам авч нэгтгэн дүгнэж, ШШГЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, цаашид анхаарч, эрчимжүүлэх ажлын талаар үүрэг, чиглэл өгөн биелэлтийг тооцон ажиглаж ирлээ. Тухайлбал:</p> <p>Монгол Улсын Засгийн газрын "Төрийн албаны сахилга, хармуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.7, Засгийн газрын "Сахилга, хармуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2017 оны 01 дүгээр албан даалгаврын 9 дэх хэсэг, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм"-ийн заалтын биелэлтийг хангуулах ажлын хүрээнд газар, албаныхаа хэмжээнд сахилга, хармуцлага, ажлын цаг ашиглалт, сонор сэрэмж, албан ажлын өрөө, тасалгааны эмх цэгц зэрэг чиглэлээр үзлэг, шалгалтыг улирал тутамд явуулан, илэрсэн зөрчлийг засуулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байна.</p>
	<p>2.2.2. Алба хаагчдын гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүгнэлт хийж, судлан харьяа нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх;</p>		<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/112 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Сахилга, ёс зүйн хорооны ажиглах журам"-ыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгон хүргүүлж, бие бүрэлдхүүнд сурталчлан судлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.</p> <p>Журамд заасны дагуу Сахилга, ёс зүйн салбар хорооны хуралдааныг зохион байгуулж, хорооноос зохион байгуулах ажлын чиглэл, удирдамж батлах, хяналт шалгалтын дүн зэрэг асуудлыг хэлэлцэн, зохих шийдвэр, алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчлийн талаар дүгнэлт гаргах зэргээр ажиглаж хэвшсэн байна.</p>
			<p>ШШГЕГ-ын Сахилга, ёс зүйн хороо 2020 онд 3 удаа хуралдан, 2019 оны ажлын тайлан, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, "Сахилга, ёс зүйн хорооны ажиглах журам"-ын төсөл зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.</p>

4		<p>ШШГЕГ-ын 4 алба хаагчийн гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийг шалгасан дүнг хэлэлцэн, тэдэнд сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэсэн Сахилга, ёс зүйн хорооны Дүгнэлт гарган ЗУГ-т уламжлан, ШШГЕГ-ын даргын тушаалаар 3 алба хаагчид албан тушаал бууруулах, 1 алба хаагчид цэргийн цолыг бууруулах сахилгын шийтгийг тус тус ногдуулсан.</p> <p>Дээрх алба хаагчдын гаргасан зөрчлийг хэлэлцсэн ШШГЕГ-ын Сахилга, ёс зүйн хорооны хуралдааны шийдвэрийг үндэслэн ШШГЕГ-ын алба, газрын дарга нарт Засгийн газрын 01 дүгээр албан даалгавар, 258 дугаар тогтоолын биелэлтийг дотооддоо шалгах үүргийг Сахилга, ёс зүйн хорооны даргын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар албан бичгээр хүргүүлэн, зохих шалгалт хийлгэхэд ноцтой зөрчил илрээгүй тухай Хорих ял эдлүүлэх алба, Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанаас хариу ирүүлсэн байна.</p> <p>- Харьяа анги, байгууллагуудын Сахилга, ёс зүйн салбар хорооны ажлын мэдээг сар, улирлаар авч танилцан нэгтгэж байгаа бөгөөд 2020 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэсэн дүнг ШШГЕГ-ын даргад танилцуулж, цаашид анхаарч ажиллах арга хэмжээний талаар ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, ШШГЕГ-ын Сахилга, ёс зүйн хорооны даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03/1714 дүгээр албан бичгээр үүрэг, чиглэл өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж ирлээ.</p> <p>- 2020 онд ШШГЕГ-ын даргын баталсан иж бүрэн хяналт шалгалтын удирамжийн дагуу ХШГ-ын алба хаагчдаар 409 дүгээр хаалттай хорих анги, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, Дорноговь аймаг дахь ШШГГ, Замын-Үүд сум дахь ШШГГХ-ийн Сахилга, ёс зүйн хорооны ажлыг шалгуулж, цаашид анхаарч ажиллах зүйлийн талаар үүрэг, чиглэл өгүүлсэн.</p> <p>Алба хаагчдын сахилга, ёс зүйн байдалд хяналт тавин, илэрсэн зөрчлийг засуулах, цаашид дахин давтан гаргуулахгүй байх зорилгоор тухайн зөрчлийн шинж байдлыг үндэслэн "Сахилгын талон", "Сахилга, хариуцлагын хуудас" ашиглах журам тогтоон мөрдүүлж, түүнд 3 удаа тэмдэглэгээ /анхааруулах, сануулах, сэргэмжлүүлэх/ хийлгэсэн тохиолдолд байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулан ажиллаж байна.</p> <p>Сахилга, ёс зүйн салбар хорооны 2020 оны жилийн эцсийн тайлан, мэдээнээс харахад анги, байгууллагууд зөрчил гаргасан нийт 983 алба</p>
---	--	---

		<p>хаагчийн асуудлыг хэлэлцэн, "Сахилгын талон"-д тэмдэглэгээ хийж, анхааруулан, сахилгын шийтгэл ногдуулахаас урьдчилан сэргийлэх, сэргэмжлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 550-аар буюу 56.5 хувиар өсч, алба хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэл 19.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>- ШШГЕГ-ын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжүүдийн Сахилга, ёс зүйн салбар хороо нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, алба хаагчдын албан үүрэг гүйцэтгэлт, сахилга, ёс зүй, хариуцлага, сонор сэргэмжийн байдалд хяналт шалгалт, үзлэг явуулан, дүнг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, анги, байгууллагын захиргаанд зөвлөмж, дүгнэлт өгөх зэргээр ажилласан.</p> <p>2020 онд харьяа нэгжүүдийн Салбар хороо нийт 404 удаа хуралдаж бие бүрэлдэхүүний сахилга, ёс зүйг дээшлүүлэх, илэрсэн зөрчлийг засуулах, цаашид дахин гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр анги, байгууллагын захиргаа, Салбар хорооны зүгээс зохих хэмжээнд анхаарал хандуулан үйл ажиллагаа нь тогтмолжин, жигдэрч байна. Хуралдааны тоо өмнөх оноос 140-оор буюу 53.0 хувиар өсчээ.</p> <p>Тайлант хугацаанд тус Салбар зөвлөлд нийт 2 өргөдөл ирснийг хүлээн авч, зохих журмын дагуу хянан шийдвэрлэж хариуг өгсөн. Тухайлбал:</p> <p>-Салбар зөвлөлд хандан гаргасан иргэн Г.Дамцагдоржийн гомдлыг хянан шалгах ажлын хэсэг байгуулан шалгаж, шалгалтын дүнг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, "хүсэлтийг хангах боломжгүй" тухай хариуг Салбар зөвлөлийн 2020.01.08-ны 01 албан бичгээр,</p> <p>-Баян-Өлгий аймгийн иргэн М.Аманханы гомдолд Салбар зөвлөлийн 2020.11.09-ний өдрийн 03 дугаар албан бичгээр хариуг тус өгсөн.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн 7 иргэний гомдолд холбогдох тайлбар гаргаж, нотлох баримтыг бүрдүүлэн 2020.01.08-ны өдрийн 04/33 дугаар албан бичигт 01/165, 2020.02.03-ны өдрийн 04/206 дугаар албан бичигт 01/725, 2020.02.12-ны өдрийн 04/281 дүгээр албан бичигт 01/845, 2020.03.10-ны өдрийн 04/456 дугаар албан бичигт 01/1322, 2020.04.17-ны өдрийн 04/727 дугаар албан бичигт 01/2079, 2020.05.08-ны өдрийн 01/892 дугаар албан бичигт 02/2485, 2020.11.04-ний өдрийн 04/1957 дугаар албан бичигт 01/529 дүгээр албан бичгээр хариуг хургуулж ажилласан.</p>
2.3. "Ил тод байдлыг хангах	2.3.1.Сул орон тооны захиалгад тулгуурлан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сул орон тооны мэдээллийг 7 хоног тутам гаргаж удирдах албан тушаалтнуудад танилцуулахын</p>
	2.2.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон төрийн алба хаагч хооронд гарсан маргааныг хүлээн авч, шийдвэрлэх;	

<p>Үзүүлэлтийг батлах тухай” Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох</p>	<p>Нөхөх тухай зарлалыг ШШГЕГ-ын цахим хуудаст байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, нээлттэй ил тод байдлыг хангах;</p>	<p>зэрэгцээ тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, шалгуурын талаарх мэдээллийг байгууллагын sd.gov.mn сайт-д, мөн нарийн мэргэжлийн эмч, сувиллагч нарын сул орон тоо, Монголын эмч нарын нэгдсэн грулт сар бүр тус тус байршуулан ажиллаж хэвшсэн. Сул орон тооны судалгааг 50 удаа гаргаж холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Мөн харьяа анги, байгууллагын хэмжээнд сул орон тооны зарыг өөрийн цахим хуудас, вэб сайт, Мэдээллийн самбар, төв, орон нутгийн ТВ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан сурталчлах ажлыг хэрэгжүүлж иржээ. Тухайлбал: Говьсүмбэр аймаг дахь ШШГГазар-425 дугаар нээлттэй хорих анги аймгийнхаа “Ард” телевизтэй хамтран хуулийн цагаар иргэдэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн талаар 2 удаагийн мэдээ мэдээлэл хийж сурталчилсан зэргээр нийт анги, байгууллагууд тодорхой ажлууд хийсэн.</p>
<p>2.3.2. Төрийн албаны зөвлөлөөс дэвшүүлсэн төрийн албан хаагчийн сургалт, хөгжилтэй холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан агуулга, хэлбэрээр нь шинэчлэн зохион байгуулах, хамтрагч байгууллагуудын хооронд зохистой хамтын ажиллагааны горимыг тогтоох зорилтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор цэргийн анги, салбарын хугацаат цэргийн алба хаагчид, МСҮТөв болон Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн оюутан, суралчдад байгууллага сурталчлах өдөрлөг, бусад арга хэмжээг зохион байгуулсан байдалд хяналт тавин, үр дүнг тооцон дүгнэх</p>	<p>Анги, байгууллагууд Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн харуул хамгаалалтын ажигтан бэлтгэх сургалтад хамрагдахыг хүссэн иргэдэд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, шалгуур, болзолын талаар ард иргэд болон Их, дээд сургууль, МСҮТ-ийн төгсөгчид, өөрсдийн нутаг дэвсгэрт байрлах цэргийн анги, нэтгэлийн алба хаагчдад мэдээлэн сурталчилж, хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн, судалж, элсэлтийн шалгалтад хамруулах зэргээр хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна. COVID-19 цар тахлын улмаас зохион байгуулах боломжгүй болсон тул нэгжүүдэд 2020.01.15-ны өдрийн 2а/187 дугаар албан бичгээр тухайн орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулах үүргийг өгсөн.</p>	
<p>2.3.3. Төрийн тусгай албан тушаалд анх орох болон Ахлагчийн сургуульд элсэн суралцах хүсэлтэй иргэнээс авах мэргэшлийн шалгалтыг ХЗДХЯ-ны Орон тооны бус зөвлөл, Дотоод хэргийн их сургууль зэрэг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;</p>	<p>Ахлагчийн сургуультай хамтран “Харуул хамгаалалтын албаны ажигтан” бэлтгэх сургалтад 267, офицер дамжаанд 17 иргэнийг тус тус сонгон шалгаруулж суралцуулсан. Мөн хүний нөөцийн санг бүрдүүлэх, нэн шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх зорилгоор МУИС-ийн “Бизнесийн сургууль”, ШУТИС-ийн “Барилга, архитектурын сургууль”, ШУТИС-ийн “Мэдээлэл, холбоо технологийн сургууль”, АШУУИС зэрэг дөрвөн сургуультай ШШГЕГ-ын хамтарсан Санамж бичиг болон захиалагч,</p>	

		<p>сургууль, суралцагчдын гурвалсан гэрээг байгуулан ажиглаж байна.</p> <p>Дээрх арга хэмжээний хүрээнд алба хаагчдад санхүүгийн ачаалал үүсгэхгүй байх зарчмыг баримтлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас сургалтын төлбөрийг бүрэн хариуцаж, 2020-2021 оны хичээлийн жилээс алба хаагч-2, алба хаагчдын хүүхэд-5, нийт-7 иргэнийг их, дээд, сургуулиудад суралцуулж эхэллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - АШУУИС-д хүний их эмч мэргэжлээр – 4; - ШУТИС-д мэдээлэл, технологийн инженер мэргэжлээр – 2; - Шинэ анагаах ухааны их сургуульд хүний их эмч мэргэжлээр – 1 суралцагчийг тус тус элсүүлэн суралцуулж байна. <p>ХЗДХС-ын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн АУ215 дугаар тушаалаар байгуулагдсан "Орон тооны бус мэргэжлийн комисс"-оос шийдвэр гүйцэтгэчийн сонгон шалгаруулалтыг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр товлон зохион байгуулж, нийт 196 оролцогчийг бүртгэж, шалгалтанд хамруулснаас 50 оролцогч сорилын болон ярилцлагын шалгалтанд тэнцэж, шийдвэр гүйцэтгэчийн нөөцөд бүртгэгдсэн.</p> <p>Шийдвэр гүйцэтгэчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 5 иргэнийг сул орон тоонд, 21 иргэнийг судлан эрүүгийн болон иргэний шийдвэр гүйцэтгэчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр албан тушаалд томилсон.</p> <p>Байгууллагын захиалгаар 2020-2021 оны хичээлийн жилд харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар, нэгжээс ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургууль, удирдлагын академид орос хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй, шаардлага хангасан 3 алба хаагч, 2 иргэн сонгон шалгаруулалтад тэнцэж, адъюнктуурт 1, магистрантуурт 1, бакалаврт 1 алба хаагч, алба хаагчийн 2 хүүхдийг суралцуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн "Хууль сахиулах удирдлага", "Стратеги-тактик удирдлага" 1.5 жилийн хөтөлбөрт 2020-2021 оны хичээлийн жилд харьяа анги, байгууллагаас нийт 14 алба хаагч суралцах хүсэлт гаргасан бөгөөд "Хууль сахиулах удирдлага" хөтөлбөрийн гаралийн сургалтад 8, "Стратеги-тактик удирдлага" хөтөлбөрийн улирлын сургалтад 6 алба хаагчийг тус тус элсүүлэн суралцуулж байна. Мөн ДХИС-ийн Ахисан шатны сургуулийн "Гэмт явдал судлал-эрх зүй" магистрын хөтөлбөрт 12, докторын өдрийн хөтөлбөрт 3, эчнээ хөтөлбөрт 1 алба хаагч тус тус элссэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, алба хаагчдын сахилга, харилцлага,</p>
	<p>2.3.4. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх, нөхөн хангалтыг хийх;</p>	
	<p>2.3.5. Үйлчлүүлэгч иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын зан харьцааны</p>	

	Талаар санал хүсэлтийг авч дүгнэх	<p>харилцааны соёл, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар санал, хүсэлтийг сонсох, үйл ажиллагаандаа дүгнэлт хийх зорилгоор "Хэрэглэгчийн үнэлгээний хуудас", "Саналын хуудас"-аар сэтгэгдлийг сонсох, үнэлгээ хийлгэх арга хэмжээг зохион байгуулж байна. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Баян-Өлгий аймаг дахь ШШГТ-азар дээрх зорилгоор 28 иргэнээс үнэлгээний хуудас бөглүүлж дүгнэхэд алба хаагчийн үйл ажиллагаатай холбогдолтой ямар нэгэн гомдол, шүүмжлэл дурдагдаагүй гэжээ. - Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги алба хаагчдын харьцаа, ёс зүйн түвшин, эргэлт, уулзалтыг зохих журмын дагуу шуурхай зохион байгуулах үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэхэд чиглэсэн 10 асуулт бүхий санал асуулгыг ангийн "Нэг цонхны үйлчилгээ"-гээр үйлчлүүлж буй шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын давхардсан тоогоор нийт 115 албан тушаалтныг хамруулан авч дүгнэхэд судалгаанд хамрагдагсдын 18 нь "Муу", 41 нь "Дунд", 56 нь "Сайн" гэж үнэлсэн байна. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Нэг цонхны үйлчилгээ"-ний төвөөр үйлчлүүлсэн 86 иргэнээс "Сэтгэл ханамжийн үнэлгээний хуудас"-аар судалгаа авч ажилласан. Иргэдийн зүгээс "Сэтгэл ханамжийн үнэлгээний хуудас"-д 51 буюу 59.3 хувь нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэн, шуурхай явуулж, мэдээллийг нээлттэй өгөхийг хүссэн; - алба хаагчдын зан харьцааны талаар саналгүй гэж 35 буюу 40.7 хувь нь бөглөжээ. <p>Санал асуулгад дүн шинжилгээ хийж, харьяа шийдвэр гүйцэтгэх газруудад 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 4/775, 4 дүгээр сарын 15-ны өдрийн 4/1105, 5 дугаар сарын 14-ний өдрийн 4/1481 дүгээр албан бичгээр тус тус уурэг, зөвлөмж өгсөн.</p>
<p>5</p> <p>судалгааг албаны баталсан графикайн дагуу гаргаж, хүргүүлэх</p>	<p>3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээний төрийн албан хаагчтай холбоотой мэдээ, тайлан, зөвлөлгөөс</p> <p>3.1.1. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг гаргах талаар харьяа нэгжийн хүний нөөцийн ажигтнуудад арга зүйн зөвлөлгөө өгөх, тайланг авч нэгтгэх;</p> <p>3.1.2. Салбар зөвлөлийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх;</p>	<p>Гурав. Төрийн захиргааны хөгжлийн бодлого, удирдлага, мэдээллийн тогтолцоо</p> <p>-Хүний нөөцийн нэгдсэн систем /hr.ssc.gov.mn/-д Нийслэл дэх хорих анги, салбар нэгж нь мэдээллээ Төрийн албаны зөвлөлд, орон нутгийн хорих анги, байгууллагуудын алба хаагчдын мэдээллийг тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд цахим хэлбэрээр тус тус хүргүүлж хэвшсэн.</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган ажиглаж байна.</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг 2020.01.15-ны өдрийн 2а/209 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.</p>

	<p>3.1.3.Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хүргүүлэх;</p>	<p>Салбар зөвлөлд хандан гаргасан 1 иргэний гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж, "хүсэлтийг хангах боломжгүй" тухай хариуг албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Салбар зөвлөлд ирүүлсэн болон бусад байгууллагаас харьяаллын дагуу шилжүүлсэн өргөдлийг хүлээн авч шалган шийдвэрлэсэн дүнгийн талаар Төрийн албаны зөвлөлд холбогдох мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.</p>
<p>3.2. Салбар зөвлөлийн ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэн сурталчлах, холбогдох мэдээллийг байршуулах зохион байгуулах ажлыг</p>	<p>3.2.1.ШШГЕГ-ын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар Төрийн албаны зөвлөлийн болон байгууллагын "Цахим хуудас"-т зохих мэдээ, мэдээллийг байршуулан, мэдээлэн сурталчлах ажлыг зохион байгуулах</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.sd.gov.mn цахим сайтад байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгууллагын бүтэц, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах албан хаагчийн нэр, албан тушаал, харилцах утас, ШШГЕГ-ын даргын иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар зэргийг тогтмол шинэчлэн байршуулсан.</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг байгууллагын цахим хуудаст байршуулан, мэдээлэн сурталчилж хэвшсэн.</p>
Дөрөв. Салбар зөвлөлийн дотоод ажлын зохион байгуулалт		
<p>6</p> <p>4.1. Салбар зөвлөлийн дотоод ажлын зохион байгуулалт, хэвийн ажиллагааг хангах</p>	<p>4.1.1.Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын хөтөлбөрийг урьдчилан гаргаж, холбогдох материалыг гишүүдэд тараан өгч танилцуулан хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны тэмдэглэлийг албажуулж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин дүгнэх;</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн "Хуралдааны дэг", "Ажил үүргийн хуваарь"-ийг шинэчлэн боловсруулж Салбар зөвлөлийн даргын 2020.01.06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулан, мөрдөж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлэн сурталчилж ажиллаж байна.</p> <p>Салбар зөвлөл нь хууль, журамд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд 2020 онд нийт 7 удаа хуралдан, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний хэрэгжилт, удирдах албан тушаалтны томилгоо болон бусад шаардлагатай цаг үеийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, холбогдох саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Төрийн албаны зөвлөлд хүргүүлж ажилласан.</p> <p>Хуралдааны хөтөлбөрийг урьдчилан гаргаж батлуулан, хэлэлцэх асуудалд холбогдох материалуудыг гишүүдэд тараан өгч, хуралдааны бэлтгэлийг зохих ёсоор хангуулан, хуралдааны тэмдэглэлийг албажуулан, архивын нэгж болгон цэгцлэн ажиллаж ирлээ.</p>

	<p>4.1.2.Салбар зөвлөлийн урьд оны баримтуудыг стандартын дагуу цэгцлэх, үдэж хавтаслан архивт шилжүүлэх</p>	<p>Салбар зөвлөлийн урьд оны 6 төрлийн баримтыг стандартын дагуу үдэж цэгцлэн, 2020.02.14-ний өдөр ШШГЕГ-ын Төв архивт шилжүүлсэн бөгөөд 2020 оны үйл ажиллагааны баримт материалыг архивт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ